

ХУ ШИ, ТҮҮНИЙ ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ

Ч.Таамаа - МУИС.ГХСС. Хятад судлалын тэнхмийн профессор
Г.Наранцэцэг - Хятад судлалын магистр

Түлхүүр үг: ашиг тус, үнэн, туршлага, зоригтойгоор таамаглахуй, болгоомжтойгоор нотлохуй.

Товч агуулга. Ху Ши нь орчин үеийн хятадын философич бөгөөд прагматизмыг хятадад түгээгч, либералист, хятадын соёлд шинэ хувьсгалыг хийсэн хүн юм. Ху Шигийн философи үзлийн эх үндэс нь Ж.Дүвэйн үзэл байсан. Ху Ши нь Ж.Дүвэйн философид тулгуурлан, “туршлага бол амьдрал, амьдрал бол хүрээлэн байгаа орчин”, туршлага болон үзэл бодол хоёр нь эргэн давтагддаг гэх үзлийг боловсруулсан юм. Туршлага, сэтгэлгээ хоёроос хамаарсан хүрээлэн буй орчноос түүний прагматист үзэл бий болжээ.

Ху Ши нь (1891-1962) Аньхуй аймгийн Жиши тосгоны хүн¹⁵. Тэрээр 1891 онд Шанхайд төрсөн. 1895-1903 оны хооронд 4-12 настайдаа өөрөө бие даан үсэг сурч, Күнзийн сургаалыг судалсан буй. 1904 онд Шанхайд ирж сургуульд суралцан хятадын соёл, англи хэлийг эзэмшсэн. Сургуулиа төгссөний дараа Японд улсын тэтгэлгээр суралцан чухамхүү тэр үеэс түүний философийн үзэл төлөвшсөн байна. Мөн суралцаж байх хугацаандаа Ху Ши хэд хэдэн зохиол бичсэн. Нэг жилийн дотор гэхэд л “Миний амирлангуй”, “Хуримын гэрээ”, “Шулуухан үг” зэрэг 24 зохиол бичсэн байдаг.

Тэрээр 1910 оны 6 сард Америкад Корнеллын их сургуульд философи болон утга зохиол судлах бөгөөд 1914 онд Колумбын их сургуульд мэргэжил дээшлүүлэн суралцан төгсөөд, 1917 онд Хятадад эргэн ирсэн. 1919 онд 26 настай байхдаа Бээжин их сургуульд уригдан, Хятадын эртний философийн түүх болон барууны философийн түүхийг зааж байжээ. 1919 оны 11 сард хятадын анхны философи судлалын хүрээлэнг үүсгэн байгуулж, Ху Ши нь тус хүрээлэнг удирдан, анхны бүтээл болох “Шинэ үеийн залуучууд” номыг эмхлэн гаргасан.

1919 онд Чень Дү Шүй, Ли Да Жэнь, Ху Ши зэрэг хүмүүс хамтран нэгэн цоо шинэ үзэл суртал бүхий сонин “Долоо хоног бүрийн шүүмжлэл”-ийг гаргах болсон. Энэ сонин дээр Ху Ши утга зохиолын хувьсгал, шинэ бүтээн байгуулалтын сэдэвтэй цөөнгүй бүтээлээ хэвлэн гаргасан. 1919 оны 4 сард түүний “Шинэ үеийн залуучууд” зохиол дээр гарсан “туршилгын тухай үзэл” нь тухайн үеийн Америкийн философийг хятадын ард түмэнд танилцуулсан хэрэг юм.

1922 онд Ху Ши нь Бээжин их сургуулийн утга зохиолын тэнхимийн эрхлэгч болсон бөгөөд “Хичээнгүй” сонинг эрхлэн гаргаж эхэлсэн байна. Тэрээр өнгөрсөн 20 жилийн хугацаандаа нэг талаар соёлын хүрээнд Хятадын эртний соёлыг дахин сэргээсэн, нөгөө талаар материалист үзлийг төлөвшүүлэн, хятадын коммунист намын үзэл сурталыг дэлгэрүүлсэн ажээ. 1926 оноос хойш Ху Ши нь барууны соёл хийгээд хятадын нийгмийн асуудлуудын талаар

¹⁵ 中国现代哲学. 北京大学出版社. 2001 年版

анхаарах болж, түүний зарим төгсөгчид нь энэ тал дээр Ху Шигийн үзлийг чанд баримтлах болсон.

1926 онд түүний бичсэн “Барууны соёлд бидний хандах хандлага”¹⁶ бүтээл гарсан. 1939 онд тэрээр Хятадын коммунист намаас Америкт суух элчин сайдаар томилогдсон юм. 1941 онд энэ албанаасаа чөлөөлөгдсөний дараа тэндээ ХартФортын их сургуульд суралцаж байгаад Японыг эсэргүүцэх дайн дууссанаас хоёр жилийн дараа эх орондоо эргэн ирж, Бээжин их сургуулийн захирлаар ажиллах болсон. 60-д оны үед Ху Ши нь Тайван болоод Америкийн хооронд улс төрийн ажлаар их явах болсон. 1958 онд Тайваны үндэсний судлалын даргаар ажиллаж байгаад 1962 оны 2 сарын 24-ны өдөр зүрхний өвчнөөр нас барсан.

Ху Ши нь прагматист үзлийг баримтлахын зэрэгцээ Хятадын үе үеийн философи сэтгэлгээний эх үндсийг тусгасан “зоригтойгоор таамаглах, болгоомжтойгоор нотлох” гэсэн үзлийг боловсруулсан. Тэр энэ арга зүйгээрээ шинжлэх ухааны судалгаагаа хийж, өөрийн олон ном зохиолоо туурвиж, тодорхой үр дүнд хүрч чадсан билээ. Түүний хамгийн алдартай бүтээл нь “Хятадын философийн түүхийн хөтөлбөр” юм. Тэрээр хятадын философийг нэлээд өрнөчилөхийн хамт хятадын философийг дэлхийд таниулсан хүний нэг юм. Ийнхүү Ху Шигийн философи нь Америкийн прагматист үзлийг гол болгохын зэрэгцээ хятадын уламжлалт философи болон уламжлалт соёлын гүнзгий нөлөөллийг тусгасан байдаг¹⁷.

Прагматист үзэл бол Америкийн философийн нэг урсгал бөгөөд түүний гол төлөөлөгч нь Ч.Пирс, У.Жеймс, Ж.Дүвэй нар болно. Ч.Пирсийн сургаал нь утгаа хамтран тохиролцож оршин тогтнох гэсэн зарчмыг баримталдаг юм. Энэ үзлээр, хүн төрөлхтний үзэл нь нийцэх, үл нийцэх гэсэн хоёр талтай байдаг. Энэ талаар тэрээр хэлэхдээ: “Нэг үзэл суртал нь бүхий л талаараа тэрхүү үзэл сурталынхаа хүний амьдрал дахь үр дүнг илэрхийлсэн байдаг. Хамгийн чухал нь юу болох, чухал биш нь юу болохыг тодорхойлсон байдаг. Тэгэхээр бид хэрвээ бүхий л талаар ямар нэгэн үзэл сурталын үр дүнг хүртэхийг хүсч байна уу, эсвэл хүсэхгүй байна уу, түүнчлэн энэ үзлээ бүрэн гүйцэд ойлгосон уу гэдгээ мэдэх хэрэгтэй. Эдгээр үр дүнгээс гадна гол нь өөрийн заяамал үзлээ хүндлэх ёстой. Энэ бол бидний прагматист үзэл суртал юм”¹⁸ гэжээ.

Энэ үзлийг уламжлан Ху Ши тайлбарлахдаа: “Аливаа үзэл сурталын сэтгэлгээ нь бүгд хувьслын үр ашгийг илэрхийлсэн байдаг ба хэрвээ утга санаа илэрхийлээгүй байвал тэр нь уг чанартаа хоосон зүйл болон хувирна. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн утга санаа үзэл суртал нь тохирон оршсоор байдаг бол утга санаа агуулаагүй үзэл суртал нь даруй үл нийцэн алга болдог” гэжээ. Энэ бол Ху Шигийн прагматист үзлийн гол ойлголт юм.

¹⁶ 中国现代哲学. 北京大学出版社. 2001 年版

¹⁷ 中国现代哲学史. 广东人民出版社. 1999 年版

¹⁸ 胡适文存. 黄山书社. 1996 年版. 第 249 页

Прагматист Ж. Дүвэй бол Ху Шигийн философи үзлийг төлөвшихөд хамгийн их нөлөө үзүүлсэн хүн юм. 1919 оны хавар Ху Шигийн бичсэн “Прагматист үзэл” хэмээх зохиолд У.Пирс, У.Жеймс, Ж. Дүвэй зэрэг хүмүүсийн философи үзлүүдээс тусгагдсан байдаг ба зохиолын бараг тэн хагасыг нь Ж. Дүвэйн философи эзэлсэн байдаг¹⁹. Энэ бүтээлд тэрээр Ж.Дүвэйн философийн үндсэн үзэл, Ж.Дүвэйн шүүмжлэлт сэтгэлгээ, Ж.Дүвэйн боловсролын философи хэмээх агуулгаар тайлбарласан буй.

1919 оны 5 сард Ж. Дү Вэй Хятадад ирэхэд Ху Ши түүнийг өөрийн философийн багш нартайгаа танилцуулсан гэдэг. Ху Шигийн философи үзэл нь Ж.Дүвэйн үзлээс олон зүйлийг уламжлан авсан. Тухайлбал, прагматист арга зүй, прагматист ёс зүй, прагматист шүүмжлэлт сэтгэлгээ зэрэг болно. Ялангуяа Дүвэйн хамгийн чухлаар Ху Шид нөлөөлсөн зүйл нь бол энэ үзлийн арга зүй юм. Энэ нь Ху Шигийн үзэлд тод илэрч байдаг.

Ж.Дүвэйн үзлийн онцлог бол өнгөрсөн туршлагынхаа үндсэн дээр шилдэг үзлийг цуглуулан гарган ирж, түүнийгээ энэ нийгмийн шалгуур болгон шат шатны зөрчилийг арилгах арга хэрэглүүр болгон ашиглахыг хүсч байсан юм. Тухайн үед Ху Ши нь энэхүү үзлийг өөртөө төлөвшүүлсний дараа эх орондоо эргэн ирсний дараагаар Америкийн нийгмийн орчинг хятадад төлөвшүүлэхийг эрмэлзэж байсан.

Хятадын орчин үеийн философи бол орчин үеийн барууны философи хийгээд хятадын уламжлалт соёлын нөлөөн дор хослон төлөвшсөн. Энэ тогтолцоо нь орчин үеийн хятадын философийн гол онцлог шинж юм. Үүний нэг жишээ нь Ху Ши-гийн философи юм. Тэрээр хятадад прагматист үзлийг төлөвшүүлэхийн зэрэгцээгээр хятадын уламжлалт философид анхаарлаа хандуулж байсан гэж хэлж болно.

Ху Ши нь бага наснаасаа уламжлалт боловсролоор хүмүүжсэн учраас түүний үзэл бодол, ой ухаан нь бүхэлдээ хятадын уламжлалт соёлоос салган авч үзэхийн аргагүй юм. Тэрээр багаасаа байнга л гэр болон нийгмийн хүмүүжлийн явцад элдэв янзын үлгэр домог, яриа хэлэлцээр, ард түмний дунд яригддаг хууч зэргийг сонсон хүмүүжсээр ирсэн. Тийм ч учраас түүний хэлж ярьсан үг бүхэн оновчтой, бодууштай тийм л үг байдаг байжээ. Түүнчлэн маш олон эртний ном зохиол, эртний мэргэдийн сургаалиудыг уншсан. Энэ мэтчилэн уншиж, сонсож явсаар нэгэнт хятадын уламжлалт соёлын нөлөөг өөртөө төлөвшүүлж, улмаар түүнийгээ өөрийнхөө сурч мэдсэн зүйлстэйгээ хослуулан өвөрмөц үзлийг бий болгож чадсан.

Иймд түүний философи үзэлд Хятадын уламжлалт философийн үзэл суртал нэвт шингэсэн байдгаас гадна бас тухайн үеийн нийгмийн үзэл сурталын нөлөөлөл ч байдаг. Мөн тэрбээр залуу насандаа олон зохиол бүтээл туурвисан байдаг ба тэр зохиол болгонд нь түүний үзэл нэвт шингэсэн байдаг.

¹⁹ 同上, 第 256 页

Хятадад шинэ нийгэм төлөвшихөд түүний оруулсан хувь нэмэр их. Түүний үзэл суртал, эхлүүлсэн үйл хэрэг, заан сургаж байсан онол номлол, шүүмжлэл зэрэг нь хятадын тухайн үеийн нийгмийн хөгжилд их ач холбогдолтой болсон гэж үздэг. Тухайн үед Хятадын ард түмэнд барууны соёл иргэншлийг танилцуулсан хүн.

Прагматист үзэл бол Хятадын орчин үеийн философийн түүхэнд хамгийн анх Хятадад орж ирсэн барууны философи болно. Тэр Хятадад эргэн ирснийхээ дараа Хятад улсад ард түмний аж амьдрал хийгээд улс төрийн салбарт өөрчлөлтийг хийж, нийгмийн шинэ бүтээн байгуулалтыг эхлүүлсэн юм. Түүнчлэн соёлын хувьсгал ид хийгдэж байх үед хүмүүст бүхий талаар их нөлөөлж байсан хүн нь Ху Ши.

Ийнхүү прагматист үзэл хятадын нийгэм, ард түмэнд нөлөөлөх болсноор хятад улс нь томоохон өөрчлөлт, шинэчлэлтэй тулгарч хуучин тогтсон байсан нүсэр том тогтолцоо нь нуран унахад хүрсэн юм. Тэр үед марксист үзэл болоод прагматист үзэл хоёр нь нэг юмны хоёр тал байсан гэж хэлж байна.

Эрхэмлэх арга бол Ху Шигийн прагматист үзлийн нэг гол арга юм. Энэ бүхнээс үзвэл, Ху Ши нь амьдралынхаа туршид Ж. Дүвэйн үзлийг шимтэн сонирхогч, мөн үргэлжлүүлэгч юм. Түүний зорилго бол Ж.Дүвэйн философи үзлийг улам бүр боловсронгуй болгон хөгжүүлж, иргэдийг түүгээрээ хүмүүжүүлэн, амьдралд тулгараад байгаа олон асуудлыг шийдвэрлэхийг зорьж байсан юм. Түүний үзсэнээр гагцхүү арга онолоор эдгээр асуудлыг засч залруулж болохгүй бөгөөд мөн үүний зэрэгцээ тэдэнд заан сургасны эцэст эдгээр асуудлыг шийдвэрлэж чадна гэж үзэж байлаа.

Ху Шигийн үзлээр, Ж.Дүвэйн философи арга нь нэг талаас таамаглалын шинжтэй, нөгөө талаас түүхэн шинжтэй. Энэ нь түүхэн урт хугацааны явцад хүн төрөлхтнийг хүмүүжүүлэн бүхий цаг хугацааны явцад хүний нийгэмтэй харилцан хамааралтай хэрэглэгдсээр ирсэн байдаг байна. Тэгэхээр эхнийх нь прагматист хандлага, харин дараагынх нь түүхэн хандлага болж байгаа юм²⁰. Түүний үзлээр, "Прагматизм нь угтаа амьдрал, харин амьдрал бол бидний хүрээлэн байгаа орчин". Хүрээлэн байгаа орчны тухайд энэ нь тасралтгүйгээр оршин тогтнож, хувиран өөрчлөгдсөөр өмнөх туршлагаараа улам бүр дэвжин дээшилсээр энэ хэмжээнд хүрсэн зүйл юм хэмээн үзэх юм бол энэ нь дан ганц оршин тогтнохын тухай асуудал биш юм.

Түүнчлэн бидний энэ орчин өргөн уудам, байнгын хөдөлгөөнд оршдогоос гадна олон асуудал урган гарч, шийдвэрлэгдэж, мөн тэдгээр зүйл хэрэглэгдсээр байдаг. Тиймээс үнэн бол ямар нэгэн адилхан үзэлт дэлхийн харилцааны тэмдэг биш, харин тэр нь туршлагаас үүдэн гарсан таамаглалын шинжтэй, эсвэл туршлага дундах албан ёсны шинжтэй байдаг. Товчоор хэлбэл, үнэн бол угтаа албан ёсоор гэрчлэгдсэн таамаглал юм.

²⁰ 杜威在中国. 自由中国. 21-4 期

Таамаглал нь нотолгоог эвдвэл эргэлзээ сэжгийг төрүүлдэг. Ху Ши хэлэхдээ: “Үнэний эх үүсвэр бол хүнээр бүтээгдсэн, хүний төлөө, хүний бүтээсэн зүйлсийн төлөө үйлчилдэг тийм зүйл юм. Яагаад гэвэл хүн л түүнийг хэрэглээнд оруулдаг, тиймээс ч хүмүүс түүнд “үнэн” гэсэн энэ нэрийг өгсөн байх л даа. Бидний үзэж байгаагаар үнэн нь угтаа хүний нэгэн хэрэглээний багаж зэвсэг төдийгүй, үнэн болон бидний гар доторхи цаас, үзэг, цай гэх мэт зүйл бүгд багаж зэвсэг юм”²¹ хэмээжээ. Ингэхээр Ху Шигийн баримталж байсан үзлийн амин сүнс бол үнэн хэмээх ойлголт юм.

Ху Ши бол шинэ үеийн соёлын хөдөлгөөнийг эхлүүлсэн төдийгүй, Хятадын уламжлалт соёлыг эрс өөрчилсөн хүн юм. Тиймээс ч түүнийг “Хятадын соёлыг дахин шинээр сэргээсэн тэмцэгч”²² хэмээн үздэг. Тэрээр Хятадын уламжлалт соёлын хийгээд орчин үеийн соёлын хоорондын ялгааг арилган, хоорондын зөрчлийг арилган нэгтгэж чадсан байна.

Ийнхүү Ху Ши нь бага наснаасаа хятадын уламжлалт боловсролоор хүмүүжсэн учраас түүний сэтгэлгээнээс хятадын уламжлалт соёлын үр нөлөөг олж харж болно. Түүнээс гадна хятадын нийгэм, ард түмэн барууны соёлын нөлөө, шинжлэх ухааны дэвшил, философийг түүний зохиол бүтээлээс сайтар танин мэдсэн онцлогтой юм.

SUMMARY

Hu Shi (1891-1962) was raised in Anhui province by his mother, his father having passed away when the child was only a little over three years old. From the village school that he first attended he went at the age of thirteen to Shanghai where he completed high school at a so-called modern school. In 1910, after receiving a scholarship, he studied at Cornell University, and he completed his Ph.D. under John Dewey at Columbia University. Under the influence of pragmatism and Dewey's ideas, he was gradually led to the conviction that China's modernization had to take place by changing ways of thinking and by writing Chinese not in the classical but in the spoken language. The latter earned him the name of "Father of the Chinese Literary Revolution."

When he returned to China in 1917 and took up an appointment at Beijing University (Beida), he quickly became one of the foremost intellectuals of his time. Advocating reforms on social, political, and intellectual issues, his was a highly influential voice for the next twenty years in discussions about reevaluating Chinese culture, so that it would be once more a viable and ongoing tradition. Like Confucius, 2500 years earlier, Hu Shi believed that tradition needed to be reevaluated in order to serve present and future development. He doubted neither China's role as a world power nor his own in the ongoing process of China's modern change.

Ном зохиол

1. 胡适. “中国哲学史”. 1996
2. 年版胡适. “四十自述”. 1993
3. 胡适. “先秦名学史”. 1983
4. “胡适哲学思想资料选”. 1981
5. 胡平编撰. “胡适之先生年谱长编初稿”. 1990
6. “胡适作品集”. (1-37 册). 1986
7. “胡适书信集”. (上中下). 1996

²¹ 胡适文存. 黄山书社. 1996 年版. 第 215 页

²² 胡适自传. 黄山书社. 1986 年版

8. 格里德. “胡适与中国的文艺复兴”. 鲁奇. 1987
9. 周明之. “胡适与中国现代知识分子的选择”. 雷. 1991
10. 欧阳哲生. 自由主义之累——胡适思想的现代. 1993
11. 张文儒, 建宁. “中国现代哲学”. 2001